



БҮРТГЭСЭН ХАНДАЛТ 399↓ (сүвгаар)

УТСААР
262↓



Суваг	2024	2025
	08.22	
	386	262
	18	12
	28	35
	34	40
	23	33
	11	17
#	499	399


Нийт дуудлага
1184↑

Хүлээн авсан дуудлага
262↓

Дуудлага авсан
24.8%↓

eMongolia-д шилжүүлсэн – 129↑
Алдсан дуудлага – 793↑

ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН БАЙГУУЛЛАГА



ХАМГИЙН ОЛОН ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ



ӨНӨӨДРИЙН ОНЦЛОХ 3 АСУУДАЛ

ОНЦЛОХ АСУУДАЛ-1

Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын дарга гэх А.Дашням нь удаа дараа архи уудаг, олон албан хаагчдынхаа амралтыг дутуу үлдээж ажилд нь хүчээр оруулдаг, ажлаа өг гэж байнга дарамталж өөрийн ажилд авсан хүмүүсээ дарга болгох гэж зүтгэдэг, өмнө нь Нийслэлд дарга байхдаа олон удаа гомдлуудыг нуун дарагдуулж байсан. Энэ асуудлыг холбогдох газраар шалган ажиллуулах талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-2

Завхан аймгийн Дөрвөлжин сумын ИТХ-аас холбогдож байна. Ерөнхий сайдын цомхотгол хийх шийдвэрээр ИТХ-аас нэг орон тоо хас гэсэн шийдвэр гарсан байна. Гуравхан хүний орон тоотой шүү дээ. Нэг хүнийг хасчихвал хэлэлцэх асуудал, шийдвэрлэх зүйлд хүрэлцэхгүй болно. Сумын ЗДТГ-т нэг хүний хийх ажлыг 4 хүн хийгээд байхад маш их ачаалалтай ажиллаж байгаа хүмүүсийг цөөлж байгаад гомдолтой байгаа талаар

ОНЦЛОХ АСУУДАЛ-3

Баянхошуунаас-Ханын материал орох замд 10 метр яваад л замд сэтгэлт хийгээд маш том нүх гарсан автомашинд ихээхэн хохирол учруулаад байна. Яаралтай замын хучилт хийж засах талаар

ШИЙДВЭРЛЭЛТ:

284↑

ХАМГИЙН ИХ ХАНДАЛТ АВСАН АСУУДАЛ: ОНЦЛОХ ГОМДОЛ

НИЙГМИЙН ДААТГАЛ

- Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газарт гомдол гаргаж байна. 2025 оны 07 дугаар сарын 12-ны өдөр төрхийн өмнөх тэтгэмж авах хүсэлт илгээсэн. Гэтэл одоо болтол санхүүжилт орж ирэхгүй байна гэсэн мэдээлэл өгөөд тэтгэмж олгогдохгүй байна. Энэ асуудлыг холбогдох газарт уламжилж өгнө үү.
- ЧД-ийн Нийгмийн даатгалын газарт ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ 05 дугаар сард өгсөн. Одоог болтол тэтгэмж ороогүй. Энэ сард орохгүй гэсэн тайлбарыг өгч байгаад гомдолтой байна. Ажилгүйдлийн тэтгэмж гэдэг чинь ажилгүй үед амьдрах мөнгө биш үү. НДЕГ-т гомдол гаргах бүрэн эрхтэй. Санхүүжилтийг цаг хугацаандаа тавихгүй юм бол яах гэж хуваарь гаргаж өгдөг юм бэ. НДЕГ-ын гомдол хүлээн авах хэсэг нь ажилладаггүй, гомдол хүлээн авах боломжгүй болгосон байна. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж шийдвэрлүүлж өгнө үү.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧДЫН ХҮНД СУРТАЛ

- СХД-ийн 43-р хороонд гомдол гаргамаар байна. 2019 онд төрсөн хүүхдийн тархины саажилттай гэсэн оноштой, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн группын сунгалтын бичиг баримтыг 05 дугаар сарын 04-нд Халамжийн хариуцсан ажилтанд өгсөн. Хариуцсан ажилтан нь байхгүй гээд шийдэж өгөхгүй 3, 4 сар боллоо. Асуудлаа яаралтай шийдвэрлүүлэх хүсэлтэй байна. Уг асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.
- ХУД-ийн ЭНЭҮТ нь өдөржин залгаад утсаа авахгүй байна. Хүн мэдээлэл авахын тулд 20-30 км туулж очмооргүй байна шүү дээ. Төрийн байгууллагууд цахимаар иргэддээ мэдээлэл өгч, утасны дуудлагаа авч баймаар байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.

ЦАХИЛГААН, ЭРЧИМ ХҮЧ

- ХУД-ийн 14 дүгээр хороо Өлзийт дэнжийн 3-23 тоотын оршин суугч байна. Манайд цахилгааны квт хэвийн хэмжээнээс бага байна. Дуудлага өгсөн боловч ирж янзалсан ч хүчдэлдээ хүрэхгүй байгаа. 3 жилийн өмнө цахилгаан сайжруулна гээд өндөр хүчдэл тавьсан байгаа боловч ашиглахгүй байна. Энэ нь хэзээ ашиглалтад орох вэ. Цахилгааны хүч дийлэхгүй байгаа нь хүндрэлтэй байна. Энэ асуудлуудыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.
- БЗД 35 дугаар хороонд цахилгаан эрчим хүчгүй, айлаас цахилгааныг 3 жил авч хэрэглэж байсан юм. Гэтэл тухайн айл нь 200,000 мянган төгрөгний төлбөр нэхэж байна. Иймд яаралтай оршин суугчдыг цахилгаан эрчим хүчинд холбон ажиллах талаар шуурхай арга хэмжээг авч ажиллана уу.

ТЕНДЕР

- "Синапс мед" ХХК нь Эдийн засаг хөгжлийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан ЭЗХЯ/20250102130 дугаартай, "Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)" төсөл -ийн багц-1 "Биотехнологийн төвийн молекул биологи, генетикийн суурь лабораторийн багаж тоног төхөөрөмж"-тендерт оролцож шалгарсан. 2025 оны 05 дугаар сарын 30 нд 2,756,600,000 (хоёр тэрбум долоон зуун тавин зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийн гэрээ байгуулах мэдэгдэл хүлээн авсан. Энэ санхүүжилт 2025 оны төсвийн тодотголоор дахин хэлэлцэгдээд 2025 улсын төсөвт суусан. Бид энэ талаар 2025 оны 07 дугаар сарын 31-ны өдөр хэвлэгдсэн 2025 оны 30 дугаартай "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд орсон байна. Гэвч захиалагч болох Эдийн засаг хөгжлийн яам одоог хүртэл гэрээгээ байгуулахгүй манай байгууллагыг хохироож байна. Эдийн засаг хөгжлийн яаманд удаа дараа гэрээ байгуулах хүсэлтээ илэрхийлсэн боловч өнөөдрийг хүртэл шийдэж өгөөгүй байна. Харин тус тендерийн багц-3 т шалгарсан "Мед Импекс Интернэшнл" ХХК -тай гэрээ байгуулсан байгаа нь тендерт оролцогч компаниудад ижил тэгш хандаагүй гэж үзэж болохоор байна. Иймд энэхүү гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэж өгнө үү.
- Манай "Топспаре Паркс" ХХК 2025 оны 01 дүгээр сарын 08-нд "Таван толгой төмөр зам" ХХК-д радио холбооны тоног төхөөрөмж нийлүүлсэн юм. Гэрээний үүргийн дагуу ажлын гүйцэтгэлээ 100 хувь хүлээлгэж өгсөн боловч дарга нь солигдсон гэдэг шалтгаанаар өнөөдрийг хүртэл санхүүжилтээ авч чадахгүй 8 сар хөөцөлдөж байгаад гомдолтой байна. Уг гомдлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.

АВТОМАШИНЫ ДУГААР

- Би нийслэлийн авто тээврийн бүртгэл хяналтын төвөөс авто машины УБ-ын сери дугаар авах гэсэн юм. Гэтэл "улсын бүртгэлд УБ -ын дугаар байхгүй. Хүмүүсийн гар дээр хадгалагдсан дугаар аваад, бүртгүүлж болно" гэсэн тайлбар өгч байгаад гомдолтой байна. Уг гомдлыг Нийслэлийн авто тээврийн бүртгэл хяналтын төвд уламжилж өгнө үү.
- Ногоон дугаарыг зөвхөн цахилгаан автомашинд өгөх ёстой байтал хосолсон хөдөлгүүрт автомашинуудад ихээр олгосон харагдаж байна. Үүнээс гадна зөвхөн цэнхэр дугаартай байх автомашинууд давхар цагаан дугаартай явж харагдах юм. Холбогдох газар автомашины улсын дугаарын олголтыг үнэн, зөв болгон ажиллана уу.